



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/67

Улаанбаатар хот

### Шуурхай штаб байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 214 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд судлан шуурхай шийдвэрлэх чиг үүрэг бүхий “Шуурхай штаб”-ыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Штабын дарга:	Х.Содномдэмбэрэл	Захиргаа, санхүүгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүн:	С.Туул	Маркетинг сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Л.Оюунхорлоо	Архив, бичиг хэргийн эрхлэгч

2. Төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд судлан түргэн шуурхай, нэг мөр эцэслэн шийдвэрлэж тайлан мэдээг тухай бүр нийслэлийн нэгдсэн штабт хүргүүлж ажиллахыг штабын гишүүдэд үүрэг болгосугай.

3. Иргэдээс байгууллага болон албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэхдээ хүнд суртал гаргасан, удаасан, шийдвэрлээгүй, хууль бус шаардлага тавьсан албан тушаалтанд танилцуулж ажиллахыг шуурхай штаб (Х.Содномдэмбэрэл)-т даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ

1150500065